

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/17/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: gereltekhburtgelaudit03@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАРАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠑᠐᠒᠒.᠐᠘.᠒᠑ № 4᠖

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Д.МӨНХБАЯР
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,689,285.75</u>	<u>29,805,914.57</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	12,636,055.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	12,636,055.00
31211	Төрийн сангийн харилцах	-	12,636,055.00
33	АВЛАГА	13,100.00	-
335	Бусад авлага	13,100.00	-
3351	Байгууллагаас авах авлага	13,100.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	17,676,185.75	17,169,859.57
354	Хангамжийн материал	17,676,192.79	17,169,859.57
35410	Бичиг хэргийн материал	2,569,825.74	4,896,888.74
35420	Аж ахуйн материал	2,558,856.00	2,112,038.00
35450	Барилгын засварын материал	751,048.00	55,775.00
35460	Хүнсний материал	1,456,154.00	199,800.00
35470	Бусад хангамжийн материал	10,340,302.01	9,905,357.83
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>316,611,266.26</u>	<u>296,673,538.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	304,971,266.26	285,033,538.43
392	Биет хөрөнгө	304,971,266.26	285,033,538.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	138,357,970.00	144,966,970.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,372,301.97)	(13,159,844.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,590,000.00	89,590,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(45,187,484.30)	(62,977,737.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	139,262,004.94	162,507,204.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,003,244.79)	(37,791,644.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,820,000.00	3,820,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,539,651.10)	(1,921,422.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(396,026.52)	(439,987.31)
393	Биет бус хөрөнгө	11,640,000.00	11,640,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,640,000.00	11,640,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>334,300,552.01</u>	<u>326,479,453.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>334,300,559.05</u>	<u>326,479,453.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	334,300,552.01	250,732,810.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	250,732,810.40	250,732,810.40
51101	Өмч: - төрийн	250,732,810.40	250,732,810.40
512	Хуримтлагдсан үр дүн	22,142,832.04	14,321,733.03
51210	Өмнөх үеийн үр дүн	(83,107,315.62)	22,142,839.08
51220	Тайлант үеийн үр дүн	105,250,147.66	(7,821,106.05)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	61,424,909.57	61,424,909.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>334,300,552.01</u>	<u>326,479,453.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	763,031,666.35	749,141,045.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	187,131,166.35	49,399,845.00
120	Нийтлэг татварын бус орлого	187,131,166.35	49,399,845.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	187,131,166.35	36,763,790.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	958,500.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	186,172,666.35	36,763,790.00
120009	Бусад орлого		12,636,055.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	575,900,500.00	699,741,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	575,900,500.00	687,741,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	575,900,500.00	687,741,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	657,781,511.65	756,962,151.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	657,781,511.65	756,962,151.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	654,157,790.62	726,550,755.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,057,216.17	487,476,970.72
210101	Үндсэн цалин	315,823,117.54	273,746,890.35
210102	Нэмэгдэл	34,884,078.81	113,624,518.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,648,500.00	34,976,000.00
210104	Урамшуулал	41,701,519.82	65,129,561.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,954,608.95	61,260,688.90
210201	Тэтгэврийн даатгал	39,353,989.33	43,263,184.19
210202	Тэтгэмжийн даатгал	2,486,660.36	4,812,704.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,978,229.62	3,756,083.93
210204	Ажилгүйдлийн даатгал	465,385.63	857,155.95
210205	Эрүүл мэндийн даатгал	7,670,344.01	8,571,560.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,429,667.75	19,201,838.10
210301	Гэрэл, цахилгаан	1,393,867.75	1,793,097.00
210302	Түлш, халаалт	15,358,640.00	16,096,861.10
210303	Цэвэр, бохир ус	677,160.00	1,311,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	84,866,142.36	24,876,024.78
210401	Бичиг хэрэг	5,970,834.00	3,838,237.00
210402	Тээвэр, шатахуун	4,296,000.00	4,764,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,872,040.00	3,619,669.56
210404	Ном, хэвлэл	12,000.00	235,820.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	209,400.00	677,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,505,868.36	11,740,598.22
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,086,998.00	9,329,876.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,000,000.00
210604	Урсгал засвар	2,086,998.00	8,329,876.00

Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	4,159,000.00	4,420,000.00
210702	Дотоод албан томилолт	4,159,000.00	4,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,959,146.06	50,936,841.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,099,618.10	47,042,443.83
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	290,000.00	290,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,175,000.00	1,175,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,000.00	107,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,100.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,224,915.06
210807	Газрын төлбөр	69,768.00	69,768.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,198,659.96	5,115.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,645,011.33	69,048,514.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		13,908,587.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,856,700.00	5,348,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,788,311.33	49,791,927.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,623,721.03	30,411,395.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	5,546,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	5,546,800.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,203,721.03	24,864,595.83
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	105,250,154.70	(7,821,106.05)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>105,250,154.70</u>	<u>(7,821,106.05)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	250,732,810.40	61,424,909.57	(83,107,315.62)	229,050,404.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	250,732,810.40	61,424,909.57	(83,107,315.62)	229,050,404.35
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	105,250,147.66	105,250,147.66
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	250,732,810.40	61,424,909.57	22,142,832.04	334,300,552.01
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	250,732,810.40	61,424,909.57	22,142,839.08	334,300,552.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	250,732,810.40	61,424,909.57	22,142,839.08	334,300,559.05
D08	Тайлант үеийн үр дүн	-		(7,821,106.05)	(7,821,106.05)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	250,732,810.40	61,424,909.57	14,321,733.03	326,479,453.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>576,859,000.00</u>	<u>712,390,355.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	958,500.00	12,649,155.00
120	Нийтлэг татварын бус орлого	958,500.00	12,649,155.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	958,500.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	958,500.00	-
120009	Бусад орлого	-	12,649,155.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	575,900,500.00	699,741,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	575,900,500.00	687,741,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	575,900,500.00	687,741,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>576,859,000.00</u>	<u>699,754,300.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	576,859,000.00	699,754,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573,235,278.97	669,342,904.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,057,216.17	487,476,970.72
210101	Үндсэн цалин	335,385,700.85	273,746,890.35
210102	Нэмэгдэл	33,748,455.76	113,624,518.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,375,330.06	34,976,000.00
210104	Урамшуулал	31,547,729.50	65,129,561.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,954,608.95	61,220,788.90
210201	Тэтгэврийн даатгал	43,003,179.97	43,223,284.19
210202	Тэтгэмжийн даатгал	1,574,364.36	4,812,704.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,248,390.62	3,756,083.93
210204	Ажилгүйдлийн даатгал	282,927.63	857,155.95
210205	Эрүүл мэндийн даатгал	5,845,746.37	8,571,560.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,429,667.75	19,201,838.10
210301	Гэрэл, цахилгаан	1,393,867.75	1,793,097.00
210302	Түлш, халаалт	15,358,640.00	16,206,841.10
210303	Цэвэр, бохир ус	677,160.00	1,201,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,128,710.00	22,728,679.56
210401	Бичиг хэрэг	3,829,810.00	6,559,955.00
210402	Тээвэр, шатахуун	4,296,000.00	4,764,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,896,100.00	3,509,669.56
210404	Ном, хэвлэл	423,400.00	433,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	209,400.00	698,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,474,000.00	6,763,035.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,087,796.00	15,200,000.00

Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,626,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	2,461,796.00	14,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,159,000.00	4,420,000.00
210702	Дотоод албан томилолт	4,159,000.00	4,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,008,368.10	53,746,626.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,347,500.10	47,082,343.83
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	290,000.00	290,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,175,000.00	1,175,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,000.00	107,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,100.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,999,915.06
210807	Газрын төлбөр	69,768.00	69,768.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,409,912.00	5,348,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,959,112.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,450,800.00	5,348,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,623,721.03	30,411,395.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	5,546,800.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	420,000.00	5,546,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	5,546,800.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,203,721.03	24,864,595.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>12,636,055.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	<u>12,636,055.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	<u>12,636,055.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	687,741,200.00	687,741,200.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	687,741,200.00	687,741,200.00	-	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	682,194,400.00	657,329,804.17	24,864,595.83	96.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,442,200.00	487,476,970.72	17,965,229.28	96.45
210101	Үндсэн цалин	285,522,800.00	273,746,890.35	11,775,909.65	95.88
210102	Нэмэгдэл	99,404,600.00	113,624,518.48	(14,219,918.48)	114.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,012,000.00	34,976,000.00	10,036,000.00	77.70
210104	Урамшуулал	75,502,800.00	65,129,561.89	10,373,238.11	86.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,090,700.00	61,220,788.90	6,869,911.10	89.91

Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	47,873,100.00	43,223,284.19	4,649,815.81	90.29
210202	Тэтгэмжийн даатгал	5,054,400.00	4,812,704.73	241,695.27	95.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,043,500.00	3,756,083.93	287,416.07	92.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,010,900.00	857,155.95	153,744.05	84.79
210205	Эрүүл мэндийн даатгал	10,108,800.00	8,571,560.10	1,537,239.90	84.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,207,100.00	19,201,838.10	5,261.90	99.97
210301	Гэрэл, цахилгаан	1,793,200.00	1,793,097.00	103.00	99.99
210302	Түлш, халаалт	16,212,000.00	16,206,841.10	5,158.90	99.97
210303	Цэвэр, бохир ус	1,201,900.00	1,201,900.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,716,700.00	22,715,579.56	1,120.44	100.00
210401	Бичиг хэрэг	6,560,000.00	6,559,955.00	45.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	4,764,000.00	4,764,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,510,500.00	3,509,669.56	830.44	99.98
210404	Ном, хэвлэл	433,400.00	433,320.00	80.00	99.98
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	698,800.00	698,700.00	100.00	99.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,750,000.00	6,749,935.00	65.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,000.00	3,200,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	2,200,000.00	2,200,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	4,420,000.00	4,420,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	4,420,000.00	4,420,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,769,700.00	53,746,626.89	23,073.11	99.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,083,300.00	47,082,343.83	956.17	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	290,000.00	290,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,175,000.00	1,175,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,600.00	107,600.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00	22,000.00	50.00

Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	4,999,915.06	84.94	100.00
210807	Газрын төлбөр	69,800.00	69,768.00	32.00	99.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,348,000.00	5,348,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,348,000.00	5,348,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,546,800.00	30,411,395.83	(24,864,595.83)	548.27
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	24,864,595.83	(24,864,595.83)	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	24,864,595.83	(24,864,595.83)	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,546,800.00	5,546,800.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,546,800.00	5,546,800.00	-	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	687,741,200.00	687,741,200.00	-	100.00
1310	Улсын төсвөөс санхүүжих	687,741,200.00	687,741,200.00	-	100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	687,741,200.00	687,741,200.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,013,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,013,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,013,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,000,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс нь Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн орлогыг бүрдүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Сангийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 13,155.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,524.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	12,636.1	12,636.1
Авлага	13.1	-	(13.1)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	17,676.2	17,169.9	(506.3)
Үндсэн хөрөнгө	316,611.3	296,673.5	(19,937.8)
Нийт хөрөнгө	334,300.6	326,479.5	(7,821.1)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	334,300.6	326,479.5	(7,821.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	334,300.6	326,479.5	(7,821.1)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 12,636.1 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Ахмадын санд төвлөрсөн хуримтлалын зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 506.3 мянган төгрөгөөр буюу 2.87 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 296,673.5 мянган төгрөг болж, 19,937.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Татварын ерөнхий газраас Сүхбаатар аймгийн Татварын

хэлтэст шилжүүлсэн Dell laptop 3510 загварын 10 ширхэг зөөврийн компьютер зэрэг нийт 23,245.5 мянган төгрөгийн биет хөрөнгөөр нэмэгдэж, тайлант хугацааны элэгдлийн зардлын 49,739.8 мянган төгрөгийн дүнгээр буурчээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 13,890.6 мянган төгрөгөөр буурсан байна. Улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 123,840.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, үнэ төлбөргүй шилжин ирсэн хөрөнгө өмнөх оноос 149,408.9 мянган төгрөгөөр буурч тус тус материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 848,722.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 848,722.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 160,981.1 мянган төгрөгөөр бууруулж, 687,741.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 687,741.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 687,741.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 687,741.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 662,876.6 мянган төгрөгийг зарцуулж, 24,864.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 12,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 12,013.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Нийт 13 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 8,691.7 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс нь 2021 онд нийт 659,917.9 мянган төгрөгийн 23 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 654,787.9 мянган төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ 654,787.9 мянган төгрөгийн 15 мэдээллийн алдаа зөрчил нь цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журам баталж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх 1 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,734.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 43.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 8,691.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Бусад хангамжийн материал данснаас аж ахуйн материал дансанд шилжүүлсэн 43.0 мянган төгрөгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 хавсралтын 6.8-д “Үйл ажиллагааны мөнгөн орлого”-д төсвөөс авсан шилжүүлгийн орлого, төсөвт байгууллагын төлбөртэй ажил үйлчилгээний орлого, тусламжийн орлого зэрэг орох бөгөөд ,, , “үнэн зөв байдал”, “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бусад хангамжийн материал данснаас аж ахуйн материал дансанд шилжүүлсэн 43.0 мянган төгрөгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэснийг дотоодын шилжилт хөдөлгөөн хийлгэж залруулсан.

4.3 Албан шаардлага

Нийт 13 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 8,691.7 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 2 ширхэг 2,004.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. **Шилэн данстай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 659,917.9 мянган төгрөгийн 23 мэдээллийг ил тод байршуулахаас 654,787.9 мянган төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Данс хооронд шилжүүлсэн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор тайлагнасан	1	43.0	1	43.0						
2	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	8,691.7					1	8,691.7		
3	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		3	8,734.7	1	43.0	-	-	1	8,691.7	1	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	654,787.9								
Дүн		1	654,787.9	-	-	-	-	-	-	1	654,787.9
Нийт дүн		3	663,522.6	1	43.0	-	-	1	8,691.7	2	654,787.9